



ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/16

Өмнөдэлгэр сум

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.7, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.6, 43.2.2, 49 дүгээр зүйлийн 49.1.1, 103 дугаар зүйлийн 103.3.2, 122 дугаар зүйлийн 122.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5, 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”, Сургуулийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургалтын менежерийн албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр, нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар, сэтгэл зүйчийн албан тушаалын тодорхойлолтыг гуравдугаар, багшийн албан тушаалын тодорхойлолтыг дөрөвдүгээр, хоол зүйчийн албан тушаалын тодорхойлолтыг тавдугаар, нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг зургаадугаар, эмчийн албан тушаалын тодорхойлолтыг долоодугаар, номын санчийн албан тушаалын тодорхойлолтыг наймдугаар, архив бичиг хэргийн албан тушаалын тодорхойлолтыг есдүгээр, няравын албан тушаалын тодорхойлолтыг аравдугаар, цахилгаанчны албан тушаалын тодорхойлолтыг арван нэгдүгээр, сантехникийн слесарийн албан тушаалын тодорхойлолтыг арван хоёрдугаар, тогоочийн албан тушаалын тодорхойлолтыг арван гуравдугаар, хичээлийн туслах ажилтан/лаборантын албан тушаалын тодорхойлолтыг арван дөрөвдүгээр, жижүүрийн албан тушаалын тодорхойлолтыг арван тавдугаар, дотуур байрны багшийн албан тушаалын тодорхойлолтыг арван зургаадугаар, дотуур байрны жижүүрийн албан тушаалын тодорхойлолтыг арван долоодугаар, үйлчлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг арван наймдугаар, гал тогооны туслагчийн албан тушаалын тодорхойлолтыг арван есдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг нийт багш, ажилтнуудад үүрэг болгосугай.

3. Багш, ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг танилцуулж, баталгаажуулж ажиллахыг Архив, бичиг хэргийн ажилтан (П.Нямсүрэн)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч (О.Бүрэнбаяр)-д даалгасугай.

ЗАХИРАЛ

Д.ШИЖИРТУЯА

